



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 03 сарын 26 өдөр

Дугаар А/230

Арвайхээр сум

Дэмжлэг үзүүлэх тухай

Хүүхдийн эрхийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.2, Сангийн сайдын 2021 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн 61 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1.6, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн "Өвөрхангай аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай" 03/03 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Өвөрхангай аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-ийн 1.4.6.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Байгаль орчноо хайрлан хамгаалах чадварыг олгох, хүүхэд, залуучуудын оролцоог нэмэгдүүлэх зорилгоор аймгийн Хүүхдийн зөвлөлөөс зохион байгуулж буй "YOUTH POWER ӨВӨРХАНГАЙ" байгальд ээлтэй хүүхэд залуучуудын чуулга уулзалтын зардалыг хавсралтаар баталсугай.

2. Чуулга уулзалтад шаардагдах 2,260,000 (хоёр сая хоёр зуун жаран мянга) төгрөгийн зардлыг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгийн зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газар (Ц.Ганболд)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



И.ДОРЖСҮРЭН

8724 11 0474

Аймгийн Засаг даргын 2024 оны 03 дугаар
сарын 26 ны өдрийн 1230 дугаар
захирамжийн хавсралт



ЧУУЛГА УУЛЗАЛТЫН ЗАРДАЛ

№	Хэрэглэгдэх бараа бүтээгдэхүүн	Хэрэгцээт тоо ширхэг	1 тоо ширхэгийн үнэ	Нийт үнийн дүн	
1.	Унааны зардал	100ш	10,000	1,000,000	
2.	Сургалтын хэрэглэгдэхүүн	120ш	6000	720,000	
3.	Баннер болон танхим засах зардал	-	-	240,000	
4.	Бичиг хэргийн зардал	Бичгийн цаас	5 боодол	20,000	100,000
		Принтерийн хор	2 ш	100,000	200,000
Нийт зардал				2,260,000	

-оОо-